

ПРАКТИКАЛ ДААТГАЛ  
ХЯНАВ





ПРАКТИКАЛ  
ДААТГАЛ

**“ПРАКТИКАЛ ДААТГАЛ” КОМПАНИЙН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ  
САХУУЖУУЛЭХТЭЙ ТЭМЦЭХЭД ЧИГЛЭСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ**

ЦДЖ-СБА-10(03)

| Хэвлэлт дугаар | Хувилбарын дугаар | Шинэчилсэн огноо | Шинэчилсэн агуулга   |
|----------------|-------------------|------------------|--|
| 2              | 2                 | 2017.08.25       | НБББББ-ийн журмын 9.2-д заасны дагуу шинээр тогтоов.   |
| 3              | 3                 | 2018.08.24       | СЗХ-ны зөвлөмжийн дагуу эцсийн өмчлөгү улс төрд нөлөө бүхий этгээд таньж мэдэх тухай зүйл нэмж оруулсан. |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |
|                |                   |                  |  |

|   |  |   |           |
|---|--|---|-----------|
|  | “ПРАКТИКАЛ ДААТГАЛ” ХХК-ИЙН МӨНГӨ<br>УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ<br>САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХЭД<br>ЧИГЛЭСЭН ДОТООД ХЯНАЛТЫН ЖУРАМ | Код:  | Хуудас: 7 |
|   |  | ПДЖ-СБА-10  |           |
| Мөрдөж эхлэх:   | 2018.09.01   |  |           |
| Танилцаж саналаа тусгасан:  | 1. Гүйцэтгэх захирал: О.Гантөмөр<br>2. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын менежер:<br>М.Замбагацэцэг                      |   |           |
| Боловсруулсан:  | Санхүү бүртгэлийн албаны дарга Б.Хишигбаяр   |   |           |

**АГУУЛГА:**

- |    |        |  |
|----|--------|--|
| 1. | Зүйл 1 | Нийтлэг үндэслэл                                 |
| 2. | Зүйл 2 | Нэр томъёоны тодорхойлолт                        |
| 3. | Зүйл 3 | Сэжигтэй гүйлгээг илрүүлэх                       |
| 4. | Зүйл 4 | Дотоод хяналтын ажилтны эрх үүрэг                |
| 5. | Зүйл 5 | Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх тайлан    |
| 6. | Зүйл 6 | Эцсийн өмчлөгчийг тодорхойлох                    |
| 7. | Зүйл 7 | Улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлох       |
| 8. | Зүйл 8 | Хариуцлага                                       |
| 9. | Зүйл 9 | Харилцагчийн талаарх баримт, материалыг хадгалах |

**ХАВСРАЛТ:**

- |    |             |  |
|----|-------------|--|
| 1. | Хавсралт №1 | Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягт   |
| 2. | Хавсралт №2 | Бэлэн мөнгөөрх гүйлгээний тайлангийн маягт   |
| 3. | Хавсралт №3 | Улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалт  |
| 4. | Хавсралт №4 | Эцсийн өмчлөгчийг илрүүлэх бүртгэлийн маягт  |
| 5. | Хавсралт №5 | Улс төрд нөлөө бүхий этгээдийн бүртгэлийн маягт  |
| 6. | Хавсралт №6 | ISIL, Al-Qaida бүлэглэлтэй холбоотой хориг арга хэмжээ болон ОФФШОР бүсэд хамаарах гадаад улс түүний нутаг дэвсгэрийн жагсаалт |



БАТЛАВ.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.ГАНТӨМӨР

**НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Энэхүү “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх” /Цаашид “Журам”/-гэх нь Практикал Даатгал ХХК /цаашид “Компани” гэх/-ийн сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх, түүний эрх, үүргийг тодорхойлоход энэхүү журмыг баримтлан ажиллана.

**ХОЁР.НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ**

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 2.1.1 “мөнгө угаах” гэж хууль бусаар олсон эд хөрөнгө гэдгийг мэдсээр байж, түүний гарал үүслийг нуун далдалж уг эд хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хууль ёсны болгох зорилгоор гүйлгээнд оруулахыг;
- 2.1.2 “терроризмыг санхүүжүүлэх” гэж террорист байгууллага болон террорист үйл ажиллагаанд зарцуулагдахыг урьдчилан мэдсээр байж аливаа хэлбэрээр эд хөрөнгө хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулахыг
- 2.1.3 “мэдээлэх үүрэгтэй этгээд” гэж /Захирлын тушаалаар томилогдсон дотоод хяналтын ажилтан/
- 2.1.4 “сэжигтэй гүйлгээ” гэж мөнгөний гарал үүсэл, эцсийн хүлээн авагч нь тодорхой бус, эсхүл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх санхүүгийн хяналтын механизм бүрдүүлээгүй улсаар дамжуулан хийсэн, түүнчлэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэж үзэж байгаа гүйлгээг
- 2.1.5 “бэлэн мөнгөний гүйлгээ” гэж үндэсний болон гадаад улсын монгол тэмдэгт, түүнчлэн олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг чек, вексель, үнэт цаас ашиглан хийсэн гүйлгээг;
- 2.1.6 “гүйлгээг түдгэлзүүлэх” гэж сэжигтэй гүйлгээний талаархи мэдээллийг шалгах зорилгоор Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан шийдвэрийн дагуу тухайн гүйлгээг түр зогсоохыг.
- 2.1.7 “бэлэн бус мөнгөний гүйлгээ” гэж олон улсын төлбөр тооцоонд түгээмэл хэрэглэгддэг төлбөрийн даалгавар, төлбөрийн нэхэмжлэл, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр хийсэн гүйлгээг.
- 2.1.8 “улс төрд нөлөө бүхий этгээд” гэж Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20.2-т заасан этгээд, эсхүл гадаад улсын түүнтэй адилтгах албан тушаалтан, олон улсын байгууллагын албан тушаалтныг;
- 2.1.9 “эцсийн өмчлөгч” гэж:
  - 2.1.9.1 харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

- 2.1.9.2 харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
- 2.1.9.3 хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;

### ГУРАВ.СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭГ ИЛРҮҮЛЭХ

- 3.1 2.1.3-т заасан этгээд нь сэжигтэй гүйлгээг илрүүлэхийн тулд харилцагчийн мэдээллийг шалгах үүрэгтэй.
- 3.1.1 Санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө;
- 3.1.2 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн гүйлгээ хийхийн өмнө;
- 3.1.3 Хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь энэ журмын 3.1.2-т заасан хэмжээнээс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ журмын 3.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол;
- 3.1.4 Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг шалгах шаардлагатай бол;
- 3.1.5 Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө;
- 3.1.6 Тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг шинжүүжүүлж үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол.
- 3.2 Энэ журмын 2.1.3-т заасан этгээд дараахь мэдээллийг харилцагчаасаа гаргуулж авна.
- 3.2.1 Харилцагч нь иргэн бол түүний эцэг /эх/-ийн нэр, нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар, иргэний үнэмлэхийн хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар;
- 3.2.2 Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /баримт бичгийг хүлээн авч байгаа эрх бүхий этгээд хуулбарыг эх хувьтай нь тулгаж, хуулбар үнэн зөв болох тухай тэмдэглэгээг үнэ төлбөргүй хийнэ/, хэрэв шуудангаар ирүүлсэн бол нотариатчаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаархи дэлгэрэнгүй танилцуулга;
- 3.2.3 Тухайн гүйлгээний утга, эцсийн хүлээн авагчийн тухай мэдээлэл;
- 3.2.4 Бэлэн бус шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай мэдээлэл.
- 3.3 Харилцагч этгээд энэ журмын 3.2-т заасан мэдээллийг өгөхөөс татгалзвал энэ журмын 2.1.3.-д заасан этгээд нь данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй
- 3.4 Өндөр дүнтэй даатгал хийлгэж байгаа төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдтэй хийх даатгалын гэрээний хураамжийн орлогоос төлөөлөгчид олгож буй шимтгэлийг төлөөлөгчийн татварын дэвтэрт бичилт хийлгэн хувийг нь авч баримтжуулан хадгалж байх.

### ДӨРӨВ.ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТНЫ ЭРХ ҮҮРЭГ

- 4.1 Энэ журмын 3.1, 3.2-т заасан гүйлгээний тухай мэдэгдэж байхыг Санхүү бүртгэлийн алба болон Даатгалын газрын ажилтнуудад сануулж мэдээлэл авч байх үүрэгтэй.
- 4.2 Энэ журмын 3.1.2, 3.1.3, 3.1.5-д заасан бэлэн ба бэлэн бус мөнгөний гүйлгээний талаар Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй.



- 4.3 Энэ журмын 4.2-д заасан гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 7 өдрийн дотор, хэрэв тухайн гүйлгээ мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилготой байсан гэж үзэх үндэслэл байгаа бол 24 цагийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд батлагдсан маягтын дагуу холбогдох мэдээллийг баримтын хамтаар хүргүүлнэ.
- 4.4 Энэ журмын 2.1.3-д заасан этгээд мэдээллийг факс, цахим хэлбэрээр, эсхүл бичгээр Санхүүгийн мэдээлэх албанд хүргүүлэх бөгөөд хэрэв утсаар хүргэсэн бол түүнийгээ нэн даруй факс буюу бичгээр баталгаажуулна.
- 4.5 Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр ажилтан, албан хаагчдын мэдлэг, ойлголтыг өргөжүүлэхэд чиглэгдсэн дотоод сургалт, семинарыг тогтмол давтамжтайгаар /жилд 2-с доошгүй удаа зохион багуулах/
- 4.6 НҮБ-ын зүгээс террорист гэж зарласан байгууллага, этгээдийн нэрсийг жагсаалттай даатгуулагч болон санхүүгийн харилцаа тогтоож байгаа этгээдийн нэрийг тулган шалгаж байх
- 4.7 Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага /FATF/-ын зүгээс мөнгө угаахтай тэмцэх тогтолцоо нь хангалтгүй, эсвэл дутагдалтай гэж үзсэн улс орны жагсаалтыг үйл ажиллагаандаа ашиглаж тэдгээр улсын харьяат хувь хүн, хуулийн этгээдийн оролцож буй гүйлгээг СМА-нд сэжигтэй гүйлгээний тайлангаар мэдээлж байх
- 4.8 Харилцаа тогтоосон болон шинээр тогтоох санхүүгийн байгууллагуудыг таньж мэдэх, учирч болзошгүй эрсдлээс өөрийн компанийг хамгаалах зорилгоор тэдгээрийн байгууллагын мөнгө угаахтай тэмцэх үйл ажиллагааны талаар асуулга, лавлагааг илгээж байх
- 4.9 Хэрэгжилтэнд хяналт тавих ажилтан нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хийсэн 20 саяаас дээш үнийн дүн бүхий гүйлгээнүүдийг бэлэн монгоний болон гадаад толбор тооцооны гүйлгээг батлагдсан маягтын дагуу ажлын тайлангаа улирал бүр компанийн хувь нийлүүлэгчид танилцуулан хувийг Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд тогтмол мэдээлж байх.

#### **ТАВ. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНД ХҮРГҮҮЛЭХ ТАЙЛАН**

- 5.1 Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх сэжигтэй гүйлгээний тухайн (хавсралт №2), бэлэн мөнгөөрх гүйлгээний тайланг (хавсралт №3)-р тус тус мэдээлэх ба мэдээлэл нь дараахь ерөнхий агуулгатай байна.
  - 5.1.1 Энэ журмын 2.1.3-д заасан этгээдийн нэр, хаяг болон мэдээлэл хүргүүлсэн албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, нэр
  - 5.1.2 Харилцагч, эцсийн хүлээн авагчийн талаархи мэдээлэл;
  - 5.1.3 Тухайн гүйлгээний утга, үнийн дүн, гүйцэтгэсэн хэлбэр, огноо, дансны дугаар, гүйлгээнд оролцогчид болон данс эзэмшигчийн талаархи мэдээлэл;
  - 5.1.4 Тухайн гүйлгээг сэжиглэх болсон үндэслэл, нөхцөл байдлын тухай товч тайлбар
  - 5.1.5 Холбогдох бусад баримт бичиг.

#### **ЗУРГАА.ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙГ ИЛРҮҮЛЭХ**

- 6.1 МУТСТ тухай хуульд заасны дагуу мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийг тодорхойлох ба эцсийн өмчлөгч гэж дараах хувь хүнийг ойлгоно.
  - 6.1.1 Харилцагчийн үйлдэл, үйл ажилагааг удирдан чиглүүлж буй эсвэл хянаж буй хүн;
  - 6.1.2 Гүйлгээг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа хүнийг;
  - 6.1.3 Хуулийн этгээдийг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээд өмчилж байвал тэдгээрийг үүсгэн байгуулсан хүн
- 6.2 Мэдээлэх үүрэгтэй этгээд нь эцсийн өмчлөгчийн бүртгэл хөтлөх шаардлагатай ба даатгалын гэрээ байгуулах, Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрөгдсөн хэмжээнд санхүүгийн түрээсийн үйлчилгээ

үзүүлэх, даатгалын хураамжийн орлогын шимтгэл олгоход сэжигтэй болон 20 сая төгрөгтэй тэнцэх хэмжээний гүйлгээг хийхдээ дээрхийн дагуу эцсийн өмчлөгчийг тодорхойлно.

6.3 Даатгалын гэрээнд даатгуулагч байгууллагын эцсийн өмчлөгчийг илрүүлэх мэдүүлгийн маягтыг даатгалын газрын ажилтан заавал бөглүүлсний үндсэн дээр гэрээ байгуулна.

6.3.1 Эцсийн өмчлөгчийн илрүүлэх мэдээллийг (хавсралт №4) маягтын дагуу бүртгэж бүртгэл хөтөлнө.

## ДОЛОО. УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ

7.1 Мэдээлэх үүрэгтэй этгээд нь дотоод хяналтын хөтөлбөртөө улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлох, тэдгээрийн харилцагчийг таньж мэдэх тухай тусгах ба 2.1.8-д зааснаас гадна дараах этгээдийг өндөр эрсдэлтэй этгээд гэж үзэж болно.

7.1.1 Гадаад орын төрийн тэргүүн, Засгийн гарын гишүүн, улс төргийн өндөр албан уаалтан, шүүх, цэрэг армийн өндөр албан тушаалтан, төрийн өмчийн аж ахуй нэгжийн удирдах албан тушаалтан, улс төрийн намын удирдлагад байсан эсхүл байгаа хувь хүнийг

7.1.2 Олон улсын байгууллагын удирдах зөвлөлийн гишүүд, захирал, орлогч, захирал басан хүнийг эсхүл байгаа хувь хүнийг

7.1.3 Улс төрд нөлөө бүхий этгээдийн гэр бүлийн гишүүд, нэгдмэл сонирхолтой этгээдийг улс төрд нөлөө бүхий этгээдтэй адил авч үзнэ;

7.1.4 Улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалт болон мэдээллийг <http://хасхот.iaac.mn/> сайтаас авч даатгалын гэрээ байгуулахдаа заавал судлаж бүртгэл хөтөлсөн байна.

7.1.4.1 Даатгалын гэрээ байгуулахдаа заавал улс төрд нөлөө бүхий этгээд ооожийг шалгана

7.1.4.2 Улс төрд нөлөө бүхий этгээдийн бүртгэлийг (хавсралт № 5) –д бүртгэнэ.

7.2 Иийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглох оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг (Хавсралт №3) болон <https://frc.mn/images/vote/ofshir.pdf> сайтаас авах ба Монгол Улсын Засгийн газрын баталсан сүүлийн тогтоолоор гаргасан улс орныг хамарна.

## НАЙМ.ХАРИУЦЛАГА

8.1 Энэ журмын 2.1.3-д заасан этгээд Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий байгууллагад энэ журмын дагуу мэдээлэл өгснийг банкны болон мэргэжлийн нууц задруулсан гэж үзэхгүй.

8.2 Даатгалын газар, Санхүү бүртгэлийн албаны ажилтнууд энэхүү журамд заасан мэдээллүүдийг мэдээлэх үүрэгтэй этгээдэд тухай бүр гаргаж өгөх үүрэгтэй ба эс бөгөөс компанийн дотоод журмын дагуу хариуцлага хүлээнэ.

8.3 Энэ журмын 2.1.3-д заасан этгээдийн өгсөн мэдээлэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгогүй байсан нь тогтоогдсон ч тухайн мэдээлэл өгсөн этгээдийг захиргааны болон эрүүгийн хариуцлагад татахыг хориглоно.

8.4 Тодорхой гүйлгээг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 11 дүгээр зүйлд заасан журмын дагуу түдгэлзүүлснээс иргэн, хуулийн этгээдэд гэм хор учирсан нь энэ журмын 2.1.3-д заасан этгээд болон Санхүүгийн мэдээллийн албыг хариуцлагад татах үндэслэл болохгүй.


### **ЕС.ХАРИЛЦАГЧИЙН ТАЛААРХ БАРИМТ, МАТЕРИАЛЫГ ХАДГАЛАХ**

- 9.1 Энэ журмын 2.1.3-д заасан этгээд нь харилцагчтай хийсэн гүйлгээ болон гэрээ, тэдгээртэй холбогдох баримт бичгийг 5-аас доошгүй жил хадгална.
- 9.2 Энэ журмын 9.1-д заасан мэдээлэл, баримт бичгийг эрх бүхий хууль сахиулах байгууллагын хүсэлтээр шуурхай гаргаж өгөхөд бэлэн байдалтай хадгална.





Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалын 3 дугаар хавсралт

|  |   |   |   |
|--|---|---|---|
|  <b>Монголбанк</b>      |   | <i>Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн дагуу 20 сая болон түүнээс дээш төгрөгийн (эсвэл түүнтэй тэнцэх гадаад валютын) бэлэн мөнгөөр хийсэн гүйлгээг мэдээлэх үүрэгтэй.</i> |   |
| <b>САНХҮҮГИЙН МЭДЭЭЛШИЙН АЛБА</b><br><b>БЭЛЭН МӨНГӨӨРХ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН</b>                             |   |   |   |
| <b>А ХЭСЭГ Кассаас Бэлэн Мөнгө Авч/Өгч Байгаа Хүний Талаарх Мэдээлэл</b>                                 |   |   |   |
| 1 Бүтэн нэр: а эцэг(эх)-ийн нэр  |   | б өөрийн нэр  | в ургийн овог   |
|  |   | 2 Бусад нэр   |   |
| 3 Төрсөн улс   | 4 Харьялал  | 5 Төрсөн огноо /он/сар/өдөр/  |   |
| 6 Бисийн байцаалтын төрөл  |   | а Бисийн байцаалтын дугаар  |   |
| 7 Оршин суугаа хаяг  |   | а Утас  |   |
| 8 Эрхэлсэн ажил, мэргэжил, үйл ажиллагаа   |   | 9 Ажлын газрын нэр, хаяг, утас  |   |
| <b>Б ХЭСЭГ Өөр Хүн/Байгууллагын Нэрийн Өмнөөс Бэлэн Мөнгө Авч/Өгч Байгаа Бол Түүний Талаарх Мэдээлэл</b> |   |   |   |
| 10 Хувь хүн/байгууллагын нэр   |   | 11 Бусад нэр  |   |
| 12 Төрсөн улс  | 13 Харьялал   | 14 Төрсөн огноо /он/сар/өдөр/   |   |
| 15 Бисийн байцаалтын төрөл (Гэрчилгээний төрөл)  |   | а Бисийн байцаалтын дугаар (Гэрчилгээний дугаар)  |   |
| 16 Ажил/бизнес/ мэргэжил/үйл ажиллагаа   |   | 17 Ажлын газрын нэр, хаяг, утас   |   |
| <b>В ХЭСЭГ Гүйлгээ Болон Түүнд Оролцож Байгаа Дансны Талаарх Мэдээлэл</b>                                |   |   |   |
| 18 Гүйлгээний нийт дүн   |   | 19 Гүйлгээ хийгдсэн огноо   |   |
|  |   | төгрөг  |   |
| 20 Гадаад валют  | 21 Дансны дугаар  |   |   |
| 22 Гүйлгээний төрөл (аль нь болохыг дугуйлна уу):  |   |   |   |
| а Харилцах/Хадгаламжийн Орлог <input type="checkbox"/>   | б Харилцах/Хадгаламжийн Зарлаг <input type="checkbox"/> | в Гадаад валют солих <input type="checkbox"/>   | г Баталгаа, батлан даалт гаргуула <input type="checkbox"/>  |
| д Данс хооронд мөнгө шилжүүлэх, гүйлгээ хийх <input type="checkbox"/>                                    | е Бэлэн мөнгө гуйвуулах <input type="checkbox"/>        | ж Үнэт цаас, төлбөрийн хэрэгсэл (чек, вексель)-ээр бэлэн мөнгө худалдаж авах <input type="checkbox"/>   | з Үнэт цаас, төлбөрийн хэрэгслийг бэлэн мөнгөөр худалдаж авах (чек, вексель) <input type="checkbox"/> |
| и Бусад <input type="checkbox"/>   |   |   |   |
| 23 Данс эзэмшигчийн бүтэн нэр  |   | а Хаяг  | б Утас  |
| <b>Г ХЭСЭГ Бэлэн Мөнгийг Хүлээн Авагч/Шилжүүлэгч Хүн/Байгууллагын Талаарх Мэдээлэл</b>                   |   |   |   |
| 24 Хүлээн авагч/Шилжүүлэгчийн нэр  |   | а Утас  |   |
| 25 Хүлээн авагч/Шилжүүлэгчийн хаяг   |   | 26 Гүйлгээний утга  |   |
| 27 Хүлээн авагч/Шилжүүлэгчийн дансны төрөл дугаар  |   | 28 Хүлээн авагч/Шилжүүлэгчийн банк  |   |
| <b>Д ХЭСЭГ Мэдээлэх Үүрэгтэй Этгээдийн Талаарх Мэдээлэл</b>  |   |   |   |
| 29 Мэдээлэх үүрэгтэй этгээдийн нэр   |   |   |   |
| 30 Хаяг  |   | 31 Гэрчилгээний дугаар  |   |
| 32 Энэхүү тайланг бэлтгэсэн ажилтны овог, нэр  |   | а Албан тушаал  | б Гарын үсэг  |
| 33 Энэхүү тайланг хянаж зөвшөөрсөн ажилтны овог, нэр   |   | а Албан тушаал  | б Гарын үсэг  |
| 34 Холбоо барих утас   | 35 Иймэйл хаяг  | 36 Тайланг бэлтгэсэн огноо  |   |

1.1.1 Улс төрд нөлөө бүхий этгээдийн жагсаалт болон мэдээллийг <http://хасхон.iaac.mn/> сайтаас авч даатгалын гэрээ байгуулахдаа заавал судлаж бүртгэл хөтөлсөн байна.



АВЛИГАГҮЙ  
НИЙГМИЙН  
ТӨЛӨӨ  
ХАМТДАА

АВЛИГА МЭДЭЭЛЭХ УТАС  
Утасны  
ТУРХИЛЛАХ 18001969

ГОМДОЛ ВГӨХ

ЭХЛЭЛ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ ХАСХОМ ХАРАХ САНАЛ ОГУУЛАХ ХАСХОМ ФАЙЛААР

Хайлтын нөхцөл

Эцэг/эх-ийн нэр:

Байгууллага:

Нэр:

Албан тушаал:

Тайлант он:

ХАЛХ

АЧИЛЖАХ

| № | Тайлант он | Овог        | Нэр          | Байгууллага                                   | Албан тушаал  |             |
|---|------------|-------------|--------------|---|---|-------------|
| 1 | 2016*      | Гэлэгпил    | Чулуунбаатар | АТГ-т мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнууд | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд          | дэлгэрэнгүй |
| 2 | 2017       | Дэлэг       | Загджав      | АТГ-т мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнууд | Уул уурхай, хүнд үйлдвэрийн дэд сайд                  | дэлгэрэнгүй |
| 3 | 2017       | Дамдинсүрэн | Хоролдэмба   | АТГ-т мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнууд | Архивын ерөнхий газрын дарга                          | дэлгэрэнгүй |
| 4 | 2017       | Бадарч      | Мөнхбат      | Сүхбаатар аймгийн ИТХ                         | Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга | дэлгэрэнгүй |









МОНГОЛБАНК

САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБА

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу 3,  
Утас: 45 00 65, Факс: (976-11) 31 14 71,  
E-mail: fiuforpublic@mongolbank.mn

2018.01.11 № 01  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Хориг арга хэмжээний тухай

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Терроризмтой тэмцэх хорооны үйл ажиллагаатай холбогдуулан ISIL, Al-Qaida бүлэглэлтэй холбоотой хориг арга хэмжээний жагсаалтад оруулсан өөрчлөлтийн талаарх SC/13144, SC/13145 тогтоолуудыг 2017 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар хүргүүлж байна.

НҮБ-ын Дүрмийн 25, 48 дугаар зүйлийн дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс баталсан шийдвэрийг НҮБ-ын гишүүн улс бүр бүрэн биелүүлэх үүрэгтэй тул дээрх тогтоолуудаар хориг арга хэмжээний жагсаалтад нэмэгдсэн болон жагсаалтаас хасагдсан хувь хүн, хуулийн этгээдийн талаар танай байгууллагын зохицуулалтад байдаг этгээдүүдэд мэдэгдэж, үйл ажиллагаандаа ашигладаг холбогдох жагсаалтыг шинэчлэхийг анхааруулна уу. Мөн Хориг арга хэмжээний жагсаалтад орсон этгээдтэй харилцаатай байсан бол нэн даруй дансыг хаах, харилцаагаа таслах, хөрөнгө битүүмжлэх, дахин шинээр харилцаа үүсгэх боломжгүй болгож, Санхүүгийн мэдээллийн албанд нэн даруй мэдэгдэх арга хэмжээ авах ажлыг зохион байгуулна уу.

Авсан арга хэмжээний талаарх мэдээллийг 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн дотор Санхүүгийн мэдээллийн албанд албан бичгээр мэдэгдэнэ үү.

НҮБ-ын SC/13144, SC/13145 тоот тогтоолоор хориг арга хэмжээний жагсаалтаас хасагдсан болон жагсаалтад нэмэгдсэн этгээдийн талаарх мэдээллийн хувийг англи хэлээр хавсаргасан болно.

Хориг арга хэмжээний дэлгэрэнгүй мэдээллийг дараах цахим хуудаснаас харна уу.

<https://www.un.org/press/en/2017/sc13144.doc.htm>

<https://www.un.org/press/en/2017/sc13145.doc.htm>

Хавсралт 4 хуудас.

Хүндэтгэсэн  
ДАРГА

Х.БАТЧУЛУУН



United Nations  Nations Unies

HEADQUARTERS • SIEGE NEW YORK, NY 10017  
 TEL.: 1 (212) 963.1234 • FAX: 1 (212) 963.4879

REFERENCE: SCA/2/17 (37)

The Chair of the Security Council Committee pursuant to resolutions 1267 (1999), 1989 (2011) and 2253 (2015) concerning ISIL (Da'esh), Al-Qaida and associated individuals, groups, undertakings and entities presents his compliments to the Permanent Representatives and Observers to the United Nations and wishes to convey the following:

On 26 December 2017, the Committee enacted the amendments specified with strikethrough/underline in the entry below on its List of individuals and entities subject to the assets freeze, travel ban and arms embargo set out in paragraph 1 of Security Council resolution 2368 (2017), adopted under Chapter VII of the Charter of the United Nations.

A. Individual associated with ISIL (Da'esh) and Al-Qaida

QDi.333 Name: 1: SCIFALLAH 2: BEN OMAR 3: BEN MOHAMED 4: BEN HASSINE ~~3-na-4~~  
 na

Name (original script): سيف الله بن عمر بن محمد بن حسين

Title: na Designation: na DOB: 8 Nov. 1965 POB: Tunis, Tunisia Good quality  
 a.k.a.: a) Seif Allah ben Hocine b) Saifallah ben Hassine c) Sayf Allah 'Umar bin Hassayn d) Seifallah ben Amor ben Hassine e) Sayf Allah bin Hussayn Low quality a.k.a.: a) Abu Iyyadh al-Tunisi b) Abou Iyadh el-Tounsi c) Abu Ayyad al-Tunisi d) Abou Aayadh e) Abou Iyadh Nationality: Tunisia Passport no: ~~na~~ Tunisia number G557170, issued on 16 Nov. 1989 National Identification no: ~~na~~ Tunisia National Identification Card 05054425, issued on 3 May 2011 (issued in Hammam Lif) Address: ~~na~~ a) 60 Rue de la Libye, Hammam Lif, Ben Arous, Tunisia b) Libya (possible location as at Jul. 2017) Listed on: 23 Sep. 2014 (amended on 15 Feb. 2017, 26 Dec. 2017) Other information: Founder of the Tunisian Combatant Group (QDe.090) and leader of Ansar al-Shari'a in Tunisia (AAS-T) (QDe.143). Arrest warrant issued by Tunisian Court of First Instance on 23 Aug. 2013. INTERPOL-UN Security Council Special Notice web link: <https://www.interpol.int/en/notice/search/un/5817982> click here

The names of individuals and entities on the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List pursuant to a decision by the Committee may be found in the "Press Releases" section on the Committee's website:

<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/press-releases>

To obtain a fully updated version of the List of individuals and entities subject to the sanctions measures, Member States are encouraged to consult, on a regular basis, the Committee's website at the following URL:

[https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/qa\\_sanctions\\_list](https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/qa_sanctions_list). The ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List is available in HTML, PDF and XML format and is updated regularly on the basis of relevant information provided by Member States and international and regional organizations.

The Consolidated United Nations Security Council Sanctions List is also updated following all changes made to the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List. An updated version of the Consolidated List is accessible via the following URL:

<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list>.

In accordance with paragraph 19 of resolution 1526 (2004), the Secretariat automatically conveys updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List to States, regional and sub-regional organizations by e-mail shortly following the postings of such updates on the Committee's website. Member States are invited to submit any updated or new contact information for this purpose to the Secretariat by e-mail to: [SC-1267-Committee@un.org](mailto:SC-1267-Committee@un.org) or fax: (+1) 212 963-1300/ (+1) 212-963-3778. The Committee encourages all States to allow implementation of updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List based on e-mails, soft-copy notices, or website postings.

26 December 2017

To obtain a fully updated version of the List of individuals and entities subject to the sanctions measures, Member States are encouraged to consult, on a regular basis, the Committee's website at the following URL:

[https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/qa\\_sanctions\\_list](https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/qa_sanctions_list). The ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List is available in HTML, PDF and XML format and is updated regularly on the basis of relevant information provided by Member States and international and regional organizations.

The Consolidated United Nations Security Council Sanctions List is also updated following all changes made to the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List. An updated version of the Consolidated List is accessible via the following URL:

<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list>.

In accordance with paragraph 19 of resolution 1526 (2004), the Secretariat automatically conveys updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List to States, regional and sub-regional organizations by e-mail shortly following the postings of such updates on the Committee's website. Member States are invited to submit any updated or new contact information for this purpose to the Secretariat by e-mail to: [SC-1267-Committee@un.org](mailto:SC-1267-Committee@un.org) or fax: (+1) 212 963-1300/ (+1) 212-963-3778. The Committee encourages all States to allow implementation of updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List based on e-mails, soft-copy notices, or website postings.

26 December 2017



The names of individuals and entities removed from the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List pursuant to a decision by the Committee may be found in the "Press Releases" section on the Committee's website:

<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/press-releases>.

To obtain a fully updated version of the List of individuals and entities subject to the sanctions measures, Member States are encouraged to consult, on a regular basis, the Committee's website at the following URL:


[https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/aq\\_sanctions\\_list](https://www.un.org/sc/suborg/en/sanctions/1267/aq_sanctions_list). The ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List is available in HTML, PDF and XML format and is updated regularly on the basis of relevant information provided by Member States and international and regional organizations.

The Consolidated United Nations Security Council Sanctions List is also updated following all changes made to the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List. An updated version of the Consolidated List is accessible via the following URL:

<https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list>.

In accordance with paragraph 19 of resolution 1526 (2004), the Secretariat automatically conveys updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List to States, regional and sub-regional organizations by e-mail shortly following the postings of such updates on the Committee's website. Member States are invited to submit any updated or new contact information for this purpose to the Secretariat by e-mail to: [SC-1267-Committee@un.org](mailto:SC-1267-Committee@un.org) or fax: (+1) 212 963-1300/ (+1) 212-963-3778. The Committee encourages all States to allow implementation of updates of the ISIL (Da'esh) and Al-Qaida Sanctions List based on e-mails, soft-copy notices, or website postings.

26 December 2017



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2017 оны 12 дугаар сарын 6-ны  
өдөр

Улаанбаатар хот

### Дугаар 326 ЖАГСААЛТ ШИНЭЧЛЭН БАТЛАХ ТУХАЙ

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 101.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргадаг албан тушаалтан, түүний хамаарал бүхий этгээд тухайн албан тушаалтны албан үүрэг гүйцэтгэх хугацаанд банкны данс нээлгэх, мөнгөн хөрөнгө байршуулах, хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх, хувь нийлүүлэх замаар хуулийн этгээд үүсгэн байгуулахыг хориглох оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Оффшор бүсэд хамаарах гадаад улс, түүний нутаг дэвсгэрийн жагсаалтыг олон улсын эдийн засаг, банк, санхүүгийн байгууллагаас гаргасан жагсаалтыг харгалзан шинэчлэн тогтоох асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байхыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Баяртсайханд зөвлөсүгэй.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2017 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 244 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР

|     |                                       |                               |
|-----|---------------------------------------|-------------------------------|
| 28. | Ирланд Улс                            | Ireland                       |
| 29. | Кайманы арлууд                        | Cayman Islands                |
| 30. | Куракао                               | Curacao                       |
| 31. | Куукийн арлууд                        | Cook Islands                  |
| 32. | Лихтенштейний Вант Улс                | Liechtenstein                 |
| 33. | Люксембург                            | Luxembourg                    |
| 34. | Макао                                 | Macao, SAR                    |
| 35. | Малайз                                | Malaysia                      |
| 36. | Маршаллын арлууд                      | Marshall Islands              |
| 37. | Монако                                | Monaco                        |
| 38. | Монтсеррат Улс                        | Montserrat                    |
| 39. | Мэний арал                            | Isle of Man                   |
| 40. | Нидерландын<br>Антиллийн Арлууд       | Netherlands Antilles          |
| 41. | Самоагийн Тусгаар улс                 | Independent State of<br>Samoa |
| 42. | Сейшелийн Арлын Бүгд<br>Найрамдах Улс | Seychelles                    |
| 43. | Сент-Винсент-Гренадин Улс             | St. Vincent and<br>Grenadines |
| 44. | Сент-Китс-Невисийн Холбооны<br>Улс    | St. Kitts and Nevis           |
| 45. | Сент-Люси Улс                         | St. Lucia                     |
| 46. | Сингапур                              | Singapore                     |
| 47. | Төрке-кайкосын арлууд                 | Turks and Caicos Islands      |
| 48. | Хонконг                               | Hong Kong, SAR                |
| 49. | Швейцар                               | Switzerland                   |